

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340.10

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас - Ерөнхий шаардлага	MNS ISO 13688:XXXX
Occupational safety and health, protective clothing - General requirement	MNS ISO 13688:2000- ын оронд

Стандартчилал, Хэмжил зүйн газрын даргын 20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ...дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь ... оны дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь хамгаалалтын хувцасны эргономик, шинж чанар, ашиглалтын хугацаа, хэмжээ, элэгдэл, хэрэглэгчийн эрүүл мэнд аюулгүй байдалд нийцсэн байдал, шошго тэмдэглэгээ, хувцастай хамт үйлдвэрлэгчээс өгөх шаардлагатай мэдээлэлд тавигдах ерөнхий үзүүлэлтийн шаардлагыг тогтооход хэрэглэнэ.

2 Норматив эшлэл

Олон улсын ISO 13688:2013 стандартыг үндэслэн боловсруулсан энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичиг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 105 Нэхмэл бүтээгдэхүүн - Өнгө тогтворжилтын сорилт

ISO 3175: 1. Нэхмэл бүтээгдэхүүн. Мэргэжлийн арчилгаа, хуурай болон нойтон цэвэрлэгээ, 1-р хэсэг: Цэвэрлэгээ ба боловсруулалтын дараах гүйцэтгэлийг үнэлэх

ISO 3175:2. Нэхмэл бүтээгдэхүүн. Хуурай болон нойтон цэвэрлэгээ, 2-р хэсэг

ISO 3175:2-2010. Нэхмэл бүтээгдэхүүн. Хуурай болон нойтон цэвэрлэгээ, 3-р хэсэг: Уусгагч бодис болон гидрокарбон ашиглан цэвэрлэгээ ба дуусгалыг үнэлэх

ISO 3635 Хувцасны хэмжээний тэмдэглэгээ. Хувцасны хэмжээний тэмдэглэгээ - Тодорхойлолт болон биеийн хэмжилт хийх арга.

ISO 3758 Нэхмэл бүтээгдэхүүн. Хэрэглэгчид зориулсан тэмдгийг шошгод кодлох.

ISO 5077 Нэхмэл бүтээгдэхүүн. Угаалга, хатаалгын дараа хэмжээний өөрчлөлтийг тодорхойлох

ISO 6330 Нэхмэл бүтээгдэхүүн турших зорилгоор гэрийн нөхцөлд угааж хатаах аргууд

3 Нэр томьёо, тодорхойлолт

3.1 Элэгдэл

Хамгаалалтын хувцасны материалуудыг тодорхой хугацаанд зориулалтын дагуу хэрэглэсний үр дүнд нэг буюу хэд хэдэн шинж чанарт нь гарч болох өөрчлөлт;

3.2 Осол

Бие гэмтэх буюу хүний эрүүл мэнд хохирох;

3.3 Аюул

Ослын бодит эх үүсвэр;

1-Р ТАЙЛБАР: Механик аюул, химийн аюул, хөлдөх аюул, өндөр температурын буюу галын аюул, биологийн хүчин зүйлсийн аюул, цацрагийн аюул гэх мэтээр аюулын үндсэн төрлүүдийг ангилдаг.

Нөхцөлөөс шалтгаалсан аюулын эдгээр тодорхой төрлүүд нь илүү өвөрмөц аюулаас үүсдэг. Тухайлбал: Өндөр температурын аюул нь дулааны эх үүсвэртэй харьцсанаас буюу дулаан тархалтаас гэх мэтчилэн үүсэх бөгөөд аюул бүрийг туршихад тохирсон аргууд байдаг. Тодорхой төрлийн ажил гүйцэтгэх явцад тохиолдож болох аюулуудаас бүхэлд нь хамгаалах зорилгоор олон төрлийн загварын хувцсыг хийдэг. Үүнд: хутганаас хамгаалах хормогч, гинжин хөрөөтэй ажиллах үед хөрөөнөөс хамгаалах өмд, химийн бодисоос хамгаалах хувцас, хурц гэрлээс хамгаалах, мотоциклийн жолоочийн хамгаалалтын хувцас зэрэг орно.

3.4 Эрсдэл

Аюултай үйл явдал- тодорхой аюулын тохиолдох давтамж буюу магадлал болон үр дагаврын хослол;

3.5 Хамгаалах хувцас

Гадны нэг болон хэд хэдэн тааламжгүй нөлөөллөөс хамгаалах зориулалтаар хийсэн хувцас;

3.6 Ашиглалтын хугацаа

Хамгаалах хувцсыг хийсэн материалын анхны шинж чанарт тодорхой хугацааны дараа гарах нэг буюу хэд хэдэн өөрчлөлт;

3.7 Ашиглалтын үр ашгийн түвшин

Сорилтын үр дүнгээр тогтоосон үр ашгийн тодорхой анги буюу зэргийг тодорхойлох тоо.

2-Р ТАЙЛБАР: Сорилтын холбогдох аргыг хэрэглэсний үр дүнд ажлын тусгай хувцасны үр ашгийг аюулаас үүдэн гарч болох хохиролтой харьцуулах боломж бүрддэг. Ихэнх тохиолдолд (сорилтын арга бүрийн) үр дүн нь ашиглалтын үр ашгийн 5 түвшинд хуваагддаг, их тоо нь үр ашгийн өндөр түвшинд харгалзана. Тодорхой стандартуудад ашиглалтын үр ашгийн янз бүрийн түвшинг тодорхойлж болох боловч тэдгээрийн сорилтын үр дүнг үнэлсэн байх ёстой.

3-Р ТАЙЛБАР: Ашиглалтын үр ашгийн мэдээг лабораторийн нөхцөл дэх сорилтын үр дүнгээр гарган авдгаас шалтгаалан эдгээр үр дүн нь ажлын байрны бодит нөхцөлтэй тохирохгүй байх тохиолдол байдаг. Иймд жинхэнэ хэрэглэгчийн нөхцөл, ажлыг тооцож, тодорхойгүй аюулын үед ажлын тусгай хувцасны үр ашгийн талаар үйлдвэрлэгчийн гаргасан мэдээллийг анхааралдаа авч ажлын тусгай хувцсыг сонгох хэрэгтэй.

4. Эрүүл мэнд болон эргономикийн шаардлага

Хамгаалалтын хувцсыг зохион бүтээх, үйлдвэрлэх үе шат нь дараах шаардлагыг

хангасан байна:

- a) Хэрэглэгчийн биеийн хэлбэрт тохирсон, хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх
- b) Ашиглах нөхцөлд тохирсон эргономик загвар бүхий байх
- c) Хүний биед хүрэлцэх хувцасны хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа үүсгэхгүй, ширүүн, хурц ирмэггүй байх,
- d) Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц буюу хэмжээний өргөн сонголттой байх,
- e) Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйлүүдийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх,
- f) Хувцасны хамгаалалтын түвшингийн найдваржилт өндөр, бөх бат хийгдсэн, хөнгөн, эдийн засгийн хувьд үр ашигтай байх.

Ажлын тусгай хувцас нь боломжийн хирээр ус ба уур нэвтрүүлэхгүй байна. Ус, уур нэвтрэлтийн сорилтын аргыг тусгай стандартаар тогтооно.

4-Р ТАЙЛБАР: ISO 11092 стандартад сорилтын олон улсын аргыг стандартчилсан. Үндэсний стандартуудад сорилтын бусад аргуудыг тусгасан байдаг. Холбогдох стандартуудад заасан үр дүнг хангахын тулд үйлдвэрлэгч ус, уур нэвтрэлтийн ангилалтад зааснаас өөр сорилтын аргыг санал болгож болно.

5-Р ТАЙЛБАР: Хэрэв хамгаалалтын шаардлагаас үүдэн ус, уур нэвтрэлтийг хангах боломжгүй бол ажлын тусгай хувцасны биед нөлөөлөх хүчин зүйлийг аль болох бага болгох хэрэгтэй.

4.1 Хоргүй байдал

Хамгаалалтын хувцасны материалын ашиглахад тохиромжтой гэсэн шаардлагыг шинжилгээгээр тогтооно.

Доор дурдагдсан зүйлсийн агууламжид онцгой анхаарал хандуулна:

- Хувиргагч бодисууд /plasticisers/
- Урвалд ороогүй бүрэлдэхүүнүүд
- Хүнд металл
- Хольц /impurities/
- Пигмент ба будагч бодисын химийн найрлага

Хамгаалалтын хувцасны материал бүр дараах шаардлагад нийцсэн байх ёстой:

- a) Арьсан хувцсан дахь хром VI-ийн агууламж нь ISO 17075-ын дагуу 3мг/кг-аас хэтрэхгүй байх.
- b) Хүний биеийн арьстай удаан хугацаанд хүрэлцэх металл эд ангийн /жишээлбэл: товч, холбоос гэх мэт/ никель ялгаруулалт нь долоо хоногт 0.5 мкг/см²- ээс бага байх. Туршилтыг EN 1811 стандартаар гүйцэтгэнэ.
- c) Хамгаалалтын хувцасны материалын pH-ийн утга нь 3.5-аас их, 9.5-аас бага байна.
- d) EN 14362-1-д жагсаасан хорт хавдар үүсгэгч ароматик амин ялгаруулж болох

азо будагч бодис нь илэрч болохгүй байх ёстой.

5 Ерөнхий зүйл

Ашиглалтын хугацааг нэг буюу хэд хэдэн хүчин зүйлээс хамааруулан ангилдаг. Энэ стандартад цэвэрлэгээний дараа ажлын тусгай хувцасны өнгө, хэмжээ тааламжгүй байдлаар өөрчлөгдөж, ажлын тусгай хувцасны ерөнхий үр ашигт нөлөөлөх байдлыг тусгасан.

5.1 Зорилго

Энэ стандартын зорилго нь хамгаалалтын хувцасны загвар зохион бүтээх, үйлдвэрлэх, нийлүүлэх, турших, шошголж тэмдэглэх, хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх мөн эцсийн хэрэглээнд ашиглах бүхий л үе шатанд мөрдөх ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

5.2 Өнгө тогтворжилт

Хэрэв холбогдох стандартад өнгө тогтворжилтын шаардлага байгаа бол хамгаалалтын хувцсыг ISO 105 стандартын холбогдох хэсгийн (тухайлбал ISO 105-B02:1988, Зохиомол гэрлийн үе дэх өнгө тогтворжилт: Ксенонон гэрэлтүүлгийн тусламжтайгаар гандалтыг сорих) дагуу сорих хэрэгтэй.

5.3 Цэвэрлэгээ

Хэрэв холбогдох стандартад цэвэрлэгээний тааламжгүй үр дүнг шалгах шаардлага байгаа бол дараах буюу тусгай стандартад заасан үйлдлийг гүйцэтгэнэ.

Хэрэв ажлын тусгай хувцасны тэмдэглэгээ нь энгийн буюу химийн аргаар цэвэрлэх ба/буюу ариутгахад тохирч байвал хамгаалалтын хувцсыг ISO 6330 стандартын дагуу цэвэрлэх бөгөөд ISO 3175 (8 ба 10 дугаар зүйлээс бусад) стандартын дагуу хими цэвэрлэгээнд хамруулна.

Цэвэрлэгээний үйл явцын холбогдох тоог тусгай стандартаар тогтоох хэрэгтэй. Хэрэв ажлын тусгай хувцсыг энгийн ба химийн аргаар цэвэрлэж болох бол энэ хоёр үйлдлийг нэг загварын хувцсанд туршина. Энэ тохиолдолд тусгай стандартад заасан үйлдэл бүрийн үйл явцын тоог хоёр дахин бага авна.

5.4 Цэвэрлэгээний дараах хэмжээний өөрчлөлт

Хэмжээний өөрчлөлтийг энгийн цэвэрлэгээний дараа ISO 5077 стандартын, хими цэвэрлэгээний дараа ISO 3175 стандартын дагуу тус тус тодорхойлно.

Тусгай стандартад өөрөөр заагаагүй бол хамгаалалтын хувцасны материалыг цэвэрлэсний дараа урт болон өргөнд гарч болох хэмжээсний өөрчлөлт дараах зөвшөөрөгдөх хязгаарт байх ёстой.

– Нэхмэл материал $\pm 3\%$

– Сүлжмэл болон нэхмэл бус материал ± 5 хувиас хэтрэхгүй байна

Нэг хослол болох хувцсыг энгийн ба химийн цэвэрлэгээний 5 удаагийн үйл явцад

хамруулна. Хэрэв энгийн ба химийн цэвэрлэгээ хоёулаа зөвшөөрөгдсөн бол зөвхөн энгийн аргаар цэвэрлэж туршина.

6 Хэмжээ

Хамгаалалтын хувцас бүрийг тухайн хувцас өмсөх хүний биеийн хэмжээг см нэгжээр илэрхийлэн тэмдэглэсэн байна. Биеийн хэмжээг үндэслэн ажлын тусгай хувцасны хэмжээг тодорхойлно. ISO 3635 стандартын дагуу биеийн хэмжээг авна. Гарын уртын хэмжээг гараа доош унжуулсан үед нь шонтон мөрнөөс бугуй хүртэлх зайг хэмжиж авна.

Ажлын тусгай хувцасны хяналтын хэмжээг хүний өндөр, цээж болон бэлхүүсний тойргийн уртаар тодорхойлно.

Хувцасны хэмжээг тогтоохдоо хамгийн багагүй бодоход хоёр удаа хяналтын хэмжээг авч гүйцэтгэнэ.

Хяналтын энэ хоёр хэмжилт нь:

- өндөр, цээжний тойрог
- өндөр, бэлхүүсний тойрог байна.

Өндөр, цээжний болон бэлхүүсний тойргийн уртын хэмжээ хүснэгт 1-д заасантай тохирч байна.

Хүснэгт 1

Өндөр, цээж болон бэлхүүсний тойргийн урт хэмжээ, см

Өндөр (интервал 6 см)	Цээжний тойрог (интервал 4 см)	Бэлхүүсний тойрог (интервал 4 см)
152-158	76-80	56-60
158-164	80-84	60-64
164-170	84-88	64-68
170-176	88-92	68-72
176-182	92-96	72-76
182-188	96-100	76-80
188-194	100-104	80-84
	104-108	84-88
	108-112	88-92
	112-116	92-96
	116-120	96-100
	120-124	100-104
		104-108
		108-112
		112-116

хүснэгт 1-д дэх үзүүлэлтүүдийг дурын сонголтоор авна. Дээр заасан интервалыг ашиглан үзүүлэлтийн утгыг өсгөн авч болно (өөрөөр хэлбэл: өндөр 194-200). Гарын урт, хөлийн урт гэх мэт нэмэлт хэмжээг үйлдвэрлэгч зааж болно. Эдгээр хэмжээ нь бодит уртын хэмжээнд тохирч см-ээр илэрхийлэгдсэн байх шаардлагатай.

Хэмжээний тэмдэглэгээнд ISO 3635 стандартад заасан стандарт пиктограммыг хэрэглэнэ.

Өндөр, цээж, бэлхүүсний тойргийн хэмжээг дээд, доод хязгаар (интервал)-ыг зааж, см-ээр илэрхийлж тэмдэглэнэ. Гарын урт, хөлийн уртыг нэг тоогоор зааж, см-ээр илэрхийлнэ.

Ажлын тусгай хувцасны хэмжээг тэмдэглэх жишээг А хавсралтад үзүүлэв.

7 Тэмдэглэгээ

Хамгаалалтын хувцасны бүх бүрэлдэхүүн хэсгүүд дээр тэмдэглэгээ байршуулсан байх ёстой.

Тэмдэглэгээ нь дараах шаардлага хангасан байна:

- Ажлын тусгай хувцсан дээр буюу түүнд бэхэлсэн шошгон дээр байрласан
- Нүдэнд харагдахуйц тод уншигдахуйц бөгөөд ойлгомжтой байх
- Цэвэрлэгээний тодорхой тооны үйл явцад арилахааргүй тогтвортой байх

Хэрэв тэмдэглэгээг хувцсан дээр байрлуулах нь хамгаалах чадварыг бууруулах, бүрэн бүтэн байдлыг алдагдуулах буюу хувцасны зориулалтад харшлах тохиолдолд тэмдэглэгээг бүтээгдэхүүний боодол дээр байрлуулна. Тэмдэглэгээ болон пиктограммыг харагдахуйц хэмжээнд том, тод, ойлгомжтой шифрээр бичсэн байна.

6-Р ТАЙЛБАР: 2 мм-ээс багагүй хэмжээтэй тоо болон 10 мм-ээс багагүй хэмжээтэй хүрээг оруулан пиктограммыг хэрэглэнэ. Тоо болон пиктограммуудыг цагаан дэвсгэр дээр хар өнгөөр хэвлэхийг зөвлөж байна.

7.1 Тусгай тэмдэглэгээ

Тусгай тэмдэглэгээнд дараах мэдээлэл байна:

- a) Нэр, барааны тэмдэг, үйлдвэрлэгч болон түүний итгэмжилсэн төлөөлөгчийн тухай бусад мэдээлэл,
- b) Бүтээгдэхүүний төрөл болон нэр,
- c) Энэ стандартын 6-ын дагуух хэмжээний тэмдэглэгээ
- d) Тухайлсан стандартын таних дугаар
- e) Пиктограмм болон ашиглалтын заавар.

Тодорхой стандартын тэмдэглэгээнд тавих шаардлагад заасны дагуу тэмдэглэгээг аюулын төрлийг тодорхойлогч пиктограммын тэмдэг (В хавсралтыг үз), хэлбэрээр хэрэглэнэ.

Жишээ нь өндөр температур буюу галаас хамгаалах хувцасны маркийг 1-р зурагт үзүүлэв.

“Ашиглалтын заавар” буюу “i” пиктограмм (зураг В2-ыг үз)-ыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зөвшилцөн хэрэглэнэ.

Ангилалд хамраагүй шаардлагын үед пиктограммтай зэрэгцүүлэн тоог хэрэглэхгүй. Ангилалд хамарсан шаардлагын үед ашиглалтын үр ашгийн түвшинг илэрхийлсэн тоог пиктограммтай зэрэгцүүлэн хэрэглэнэ. Эдгээр тоог холбогдох стандартад заасны дагуу байнга тодорхой дарааллын дагуу байрлуулна.

7-Р ТАЙЛБАР: Эдгээр тоо нь пиктограммын ард баруун гар талаас цагийн зүүний дагуу байрласан байна

- f) Хамгаалах хаяг, угаах буюу цэвэрлэхтэй холбогдсон зааварчлагыг ISO 3758 стандарттай нийцүүлэн хэрэглэнэ.

Хэрэв цэвэрлэгээний үйл явцын тоог тэмдэглэх онцгой шаардлага байгаа бол үйл явцын хамгийн их тоог “мах” гэсний дараа хамгаалах хаягтай зэрэгцүүлэн байрлуулна.

ЖИШЭЭ НЬ:

мах. 25х

Хэрэв үйлдвэрлэгч ашиглалтын зааврыг зөвшилцөх шаардлагатай гэж үзэж байгаа бол “ISO 7000-1641 Ашиглалтын заавар” пиктограмм (зураг В2-ыг үз)-ыг ISO 3758 стандартын хамгаалах тэмдгийн өмнө байрлуулна.

- g) Зарим холбогдох тэмдэглэгээг хэрэглэж болно, жишээлбэл, шаардлагатай анхааруулга.



Зураг 1 – ISO 7000-2417

8 Үйлдвэрлэгчийн мэдээлэл

Ажлын хувцсыг очих улсын албан ёсны хэл дээр бичсэн мэдээллийн хамт хэрэглэгчид хүргэнэ. Бүх мэдээлэл ойлгомжтой байна. Үүнд дараах мэдээлэл багтсан байна:


- a) Үйлдвэрлэгчийн буюу түүний итгэмжилсэн төлөөлөгчийн нэр болон бүтэн хаяг
- b) Энэ стандартын 7.2-ын дагуух бүтээгдэхүүний зориулалт
- c) Бүтээгдэхүүний стандартын дугаар
- d) Пиктограмм болон ашиглалтын үр ашгийн түвшингийн тайлбар, хамгаалалтын хувцсанд хийх туршилтын ерөнхий тайлбар, ашиглалтын үр ашгийн түвшингийн жагсаалт зэргийг хүснэгтэд үзүүлнэ.
- e) Ашиглалтын заавар:
 - Ашиглалтын өмнөх туршилт (шаардлагатай тохиолдолд)
 - Өмсөж тайлах арга (шаардлагатай тохиолдолд)

- Хэрэглэх арга, хэрэглээний талаарх үндсэн мэдээллийг өгч илүү дэлгэрэнгүй мэдээллийн эх үүсвэрийг зааж өгнө.
 - Хэрэглээний хязгаарлалт (температурын горим зэрэг)
 - Хадгалалт үйлчилгээний дүрэм, төлөвлөгөөт хяналт хоорондын хугацааг заана.
 - Цэвэрлэгээ болон ариутгалын заавар
 - Гарч болзошгүй гэмтлийн тухай сануулга
 - Танилцуулга болон сэлбэг, тавилгын жагсаалт
- f) Туслах болон нөөц хэрэгслийн эшлэл (шаардлагатай тохиолдолд)
- g) Тээвэрлэх үеийн сав баглаа боодолд тавих шаардлага (шаардлагатай тохиолдолд)


ТӨГСӨВ.

А. Хавсралт
(мэдээллийн)





Ажлын тусгай хувцасны хэмжээг тэмдэглэх жишээнүүд



Зураг А.1 Костюм, цув, хүрэмд тавих шаардлага



Зураг А. 2 Өмдөнд тавих шаардлага



Зураг А. 3 Бусад хувилбарууд

В хавсралт
(мэдээллийн)

Пиктограмм

1997 оны дунд үеэс В хавсралтад жагсаасан пиктограмм ажлын тусгай хувцасны тухайлсан стандарт хэрэглэдэг болсон

Хүснэгт В.1

Хамгаалалтын зориулалтын төрлийг заасан пиктограммууд



Пиктограммууд	Хамгаалалтын зориулалт	Пиктограммууд	Хамгаалалтын зориулалт
	Ионжуулагч цацрагаас хамгаалах ISO 7000-2809		Гинжит хөрөөнөөс хамгаалах ISO 7000-2416
	Хөдөлгөөнт хэсгээс хамгаалах ISO 7000-2411		Халуун ба галаас хамгаалах ISO 7000-2417
	Хүйтнээс хамгаалах ISO 7000-2412		Хутга, мэсээс Хамгаалах ISO 7000-2483
	Цаг уурын нөлөөнөөс хамгаалах ISO 7000-2413		Цацраг идэвхит бодисоос хамгаалах ISO 7000-2484
	Химийн бодисоос хамгаалах ISO 7000-2414		Гагнуурын ажилтай холбоотой эрсдэлээс хамгаалах ISO 7000-2683
	Статик цахилгаан гүйдлээс хамгаалах ISO 7000-2415		Микро организмын аюулаас хамгаалах ISO 7000-2491
	Үйлдвэрлэсэн Огноо ISO 7000-2497		Хадгалах хугацаа дуусах огноо ISO 7000-2607


	Цахилгаан нумын үүсгэх дулааны эрсдэлээс хамгаалах IEC 60417-6353	
Тайлбар: Аюулаас хамгаалахыг сануулсан дүрсэн дэх пиктограммууд нь ажлын тусгай хувцсанд хамаарна. Аюулын төрлийг хүрээний доторхи дүрсээр илэрхийлнэ.		

В. Хавсралтын үргэлжлэл

Хүснэгт В. 2


Ажлын тусгай хувцасны хэрэглээний зориулалтыг заасан пиктограммууд

			
Гал унтраах зориулалтын ажлын тусгай хувцас (хэрэгсэл)	Тод үзэгдэх зориулалтын ажлын хувцас (хэрэгсэл)	Өнгөлөгч нунтаг шүрших ажлын зориулалтын ажлын тусгай хувцас (хэрэгсэл)	Мотоциклчдын тусгай хувцас (хэрэгсэл)
ISO 7000-2418	ISO 7000-2419	ISO-2482	ISO 7000-2618
8-Р ТАЙЛБАР: Квадрат хүрээн дэх пиктограммууд нь ажлын тусгай хувцасны зориулалтыг заана. Хэрэглээний төрлийг квадрат хүрээний доторх дүрс илэрхийлнэ.			



Зураг В.1- ISO 7000-ажлын тусгай хувцасны суурь тэмдэг

В. Хавсралтын үргэлжлэл



Зураг В.2-ISO 7000-1641 “Ашиглалтын заавар”